



**БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 03 сарын 26 өдөр

Дугаар A/65

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Боловсролын яамны 2025 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг нэгдүгээр, Шударга байдлын үнэлгээг сайжруулах 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.


2.Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж ажиллахыг газар, хэлтсийн дарга нар, харьяа байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулж, мэдээлэл, арга зүйн удирдлагаар ханган, хагас, бүтэн жилээр тайлагнаж ажиллахыг Төрийн захиргааны удирдлагын газар (Б.Алтансүх)-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Х.БАТЖАРГАЛ



14252 2276



Төрийн нарийн бичгийн даргын
2025 оны 03 сарын 03 ний өдрийн
тоот тушаалын нэгдүгээр хавсралт

165

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ 2025 ОНЫ АВЛИГЫН ЭСРЭГ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах газар
Зорилт 1. Авлигын эсрэг хууль тогтоомжийг иргэдэд сурталчлах, соён гэгээрүүлэх үйл ажиллагааны хүртээмжийг нэмэгдүүлэх					
1.1	Авлигатай тэмцэх газраас соён гэгээрүүлэх чиглэлээр бэлтгэсэн контентуудыг байгууллагын албан ёсны цахим хуудас, сувгаар суртчилсан мэдээ, сошиал сувгаар сурталчилж, олон нийтэд хүргэх	Байгууллагын албан ёсны цахим хуудас, сошиал сувгаар суртчилсан мэдээ, мэдээллийн тоо	Цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийг тухай бүр Боловсролын яам болон харьяа байгууллагуудын албан ёсны цахим хуудас, пэйж хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн сурталчилсан байна.	I-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар, харьяа байгууллагууд
1.2	Байгууллагын эрх хэмжээ, үйл ажиллагаатай холбогдуулан эрхлэн гаргадаг ном гарын авлага, сэтгүүл, иргэдэд тараадаг хэвлэмэл материал болон бусад хэлбэрээр авлигыг мэдээлэх 110 дугаарыг сурталчлах	110 дугаарыг суртчилсан сурталчилгааны тоо	Ном гарын авлага, сэтгүүл болон бусад хэлбэрээр авлигыг мэдээлэх 110 дугаарын утсыг олон нийтэд сурталчлах ажлыг зохион байгуулсан байна.	I-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар, харьяа байгууллагууд
1.3	Боловсролын салбарын оролцогчдод чиглэсэн ёс зүй, шударга байдлыг уриалсан агуулга бүхий 6-аас доошгүй видео контент, рийл бүтээж, олон нийтэд хүргэсэн байх	Ёс зүй, шударга байдлыг уриалсан видео контент, рийлийн тоо	Боловсролын салбарт шударга ёсыг түгээн дэлгэрүүлэх, соён гэгээрүүлэх, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх 6-аас доошгүй контент бүтээж олон нийтэд хүргэсэн байна.	II-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар
Зорилт 2. Ил тод байдлыг сайжруулах, хүнд суртал, чирэгдлийн бууруулах, олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх					

2.1	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх хяналтын хэрэгжүүлэх	Журмын хэрэгжилтийг хангах хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тоо	“Төрийн байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг хэрэгжүүлэх журам”-ын хэрэгжилтийг хангаж олон нийтийн байгууллагатай хамтран ажилласан байна.	I-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар
2.2	Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн талаарх мэдээллийн нээлттэй, ил тод байдлыг хангах	Цахим хуудсанд байршуулсан мэдээ, мэдээллийн тоо	Яамны цахим хуудсанд ирэх оны төлөвлөлт болон тухайн жилийн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн мэдээллийг сар бүр шинэчлэн байршуулсан байна.	II-IV улирал	Хөрөнгө оруулалтын хэлтэс
2.3	Төсвийн тухай хуулийн Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагын дагуу олон нийтийн саналыг авах, оролцоог хангах зорилтын хүрээнд www.publicinvestment.gov.mn цахим хуудас болон гар утасны “Төсвийн хөрөнгө оруулалт” аппликэйшнээр дамжуулан иргэдээс санал авч нэгтгэх	Иргэдээс ирүүлсэн санал хүсэлтийн	Иргэдийн санал хүсэлтэд үндэслэсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг боловсруулж Сангийн сайдад хүргүүлсэн байна.	I-IV улирал	Хөрөнгө оруулалтын хэлтэс
Зорилт 3. Авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэх шалтгаан, нөхцөлийг арилгуулах арга хэмжээ авах					
3.1	Авлигын эрсдэл ба авлига гарах боломжийг бууруулах хүрээнд иргэд, олон нийтэд үзүүлж буй цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр арга хэмжээг зохион байгуулах	цахим үйлчилгээг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулсан байна.	I-IV улирал	Цахим боловсролын газар, Гадаад хамтын ажиллагааны газар
3.2	Төрийн байгууллага, хувийн хэвшлийн хооронд байгуулах аливаа гэрээ хэлэлцээрт авлигаас урьдчилан сэргийлэх	-Гэрээнд тусгайлан заалт оруулах	Боловсролын яамтай хамтран ажиллах чиглэлээр байгуулсан бүх төрлийн гэрээнд авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, шаардлагатай	I-IV улирал	Хууль эрх зүйн хэлтэс

	асуудлыг тусгах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авсан байх;	-Байгуулсан гэрээний тоо,	бол мэдэгдэл тайлбар гаргах агуулга бүхий заалт тусгаж гэрээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.		
3.3	Их, дээд сургуулийн орчинд шударга ёсны үзэл санааг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Багш, ажилтан, суралцагчдад авлигаас ангид, ёс зүйтэй байхыг уриалсан, авлига, түүний хор уршгийг таниулах, нийгэмд эерэг хандлагыг түгээн дэлгэрүүлэх чиглэлээр арга хэмжээ зохион байгуулсан байна.	II-IV улирал	Дээд боловсролын газар
3.4	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн шинэчлэн батлагдсан хууль, дүрэм журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	-Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь -Илэрсэн зөрчлийн тоо, хувь	Хяналт шалгалт хийгдэж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр тухайн байгууллагатай хамтран ажилласан байна.	III-IV улирал	Салбарын хяналтын газар
3.5	Төлөвлөгөөт хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийсэн байгууллагад гарсан зөрчлийг ангилан "Нийтийн албанд нийтийн болон хувийн нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" зөрчсөн тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх	Шалгалтад хамрагдсан байгууллагын тоо	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит хийж гарсан зөрчлийг ангилан "Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль" зөрчсөн тохиолдолд холбогдох хууль хяналтын байгууллагад шилжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн байна.	I-IV улирал	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
3.6	Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт шударга ёсны боловсрол олгох агуулгыг оруулах	Хөтөлбөр батлуулснаар	Ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сургалтын хөтөлбөрт шударга ёсны боловсрол олгох агуулгыг тусгасан байна.	I-IV улирал	Боловсрол судлалын үндэсний хүрээлэн
3.7	"Сургуулийн соёл, суралцагчийн төлөвшил" дэд хөтөлбөр боловсруулж батлуулах	Дэд хөтөлбөр	"Сургуулийн соёл, суралцагчийн төлөвшил" дэд хөтөлбөр батлагдсан байна.	II-IV улирал	Ерөнхий боловсролын газар

Төрийн нарийн бичгийн даргын
2025 оны 03 сарын 26 ний өдрийн
А... тоот тушаалын хоёрдугаар хавсралт
/65

БОЛОВСРОЛЫН ЯАМНЫ ШУДАРГА БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭГ САЙЖРУУЛАХ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах газар
Гадаад шударга байдлыг сайжруулах чиглэлээр					
1.1	Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна. Албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх мэдлэг дээшилж, дотоод хяналт сайжирсан байна.	II-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар
1.2	Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохируулан иргэд, олон нийтэд чиглэсэн нээлттэй хаалганы өдөрлөг, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-Нээлттэй хаалганы өдөрлөг оролцсон иргэдийн тоо -Зөвлөгөө, дэмжлэг үзүүлсэн үйлчилгээний тоо	Олон нийтэд чиглэсэн нээлттэй хаалганы өдөрлөг, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулсан байна.	II-IV улирал	Боловсролын зээлийн сан
1.3	Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагаа, тэдгээрийн шинэчлэн батлагдсан хууль, дүрэм журмын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	-Хяналт шалгалт хийсэн объектын тоо, гүйцэтгэлийн хувь -Илэрсэн зөрчлийн тоо, хувь	Хяналт шалгалт хийгдэж илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах чиглэлээр тухайн байгууллагатай хамтран ажилласан байна.	III-IV улирал	Салбарын хяналтын газар
1.4	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх	Өргөдөл, гомдлын тоо,	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын өргөдөл, хүсэлт, гомдол мэдээлэл, эрх бүхий байгууллагын	I-IV улирал	Салбарын хяналтын газар

		шийдвэрлэлтийн хувь	шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийж үр дүнг танилцуулсан байна.		
1.5	Үндэсний аудитын газраас болон хязгаарлалттай санал дүгнэлт авсан харьяа байгууллагуудад арга зүйн дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө мэдээллийн тоо	Үндэсний аудитын газраас сөрөг болон хязгаарлалттай санал дүгнэлт авсан харьяа байгууллагуудад арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.	I-IV улирал	Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар
1.6	Товш аппликэйшний мэдээлэлд үндэслэн харьяа байгууллагуудаар үйлчлүүлсэн иргэдийн санал хүсэлтийн дагуу тухайн байгууллагуудын үйлчилгээг сайжруулах чиглэлд зөвлөгөө, дэмжлэг үзүүлэх	Зөвлөгөө мэдээллийн тоо	Товш аппликэйшнээр сөрөг үнэлгээ авсан харьяа байгууллагуудад арга зүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлж хамтран ажилласан байна.	I-IV улирал	Холбогдох газар, хэлтсүүд
1.7	Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудад зориулсан "Нийгмийн ажилтны оролцоо, хүүхдийн шударга байдал" сургалт зохион байгуулах	Сургалт, мэдээллийн тоо	Ерөнхий боловсролын сургуулийн нийгмийн ажилтнуудад зориулсан "Нийгмийн ажилтны оролцоо, хүүхдийн шударга байдал" сургалт зохион байгуулсан байна.	II-IV улирал	Ерөнхий боловсролын газар
Дотоод шударга байдлыг сайжруулах чиглэлээр					
2.1	Байгууллагын дотоод хяналтын механизмыг сайжруулж, албан хаагчдыг авлига, ашиг сонирхлоос ангид байхад чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлэх	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо	Албан хаагчдыг авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байхад чиглэсэн арга хэмжээ зохион байгуулсан байна. Албан хаагчдын авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх мэдлэг дээшилж, дотоод хяналт сайжирсан байна.	II-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар
2.2	Байгууллагын соёл - багшийн ёс зүйн жилийн хүрээнд "Боловсролын байгууллагын багшийн хандлагын шинэчлэл" сургалт зохион байгуулах	Сургалтын тоо, сургалтад хамрагдсан багш нарын тоо	Боловсролын сургалтын байгууллагад ажиллаж байгаа багш, ажилчдын ёс зүй, хандлага сайжирсан байна.	II-IV улирал	Ерөнхий боловсролын газар

2.3	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үйл ажиллагаанд иргэний нийгмийн оролцоо, хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр хамтран ажилласан иргэний нийгмийн байгууллагын тоо	Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажилласан байна.	II-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар
2.4	Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах, аливаа дэмжлэг урамшууллыг ил тод нээлттэй болгох	Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах чиглэлээр арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.	Яамны албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгаа сайжирсан байна. Энэ чиглэлийн үйл ажиллагаа ил тод, нээлттэй болсон байна.	II-IV улирал	Төрийн захиргааны удирдлагын газар